



Бүтээлээрээ холбогдсон гавьяатууд



Улаанбаатар
2017 он

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль



Ерөнхий редактор:

Б.Тулгабат - Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн
(Утга зохиолын төлөө шагналт, МУСТА, зохиолч
сэтгүүлч)

Хянан тохиолдуулж ариутгасан:

Ч.Сандаг - "Арвин судар" ерөнхий захирал

ISBN: 978-99978-0-312-2



Ном гэдэг агуу их буян ажээ

Залуу насаа хүн ардынхаа төлөө, энэрэнгүй үйлст зориулж, эх орныхоо дөрвөн зүг, найман зовхист, “Энхийн соргог манаанд” өчүүхэн биесээ үл хайрлан нэгэн насаа элээж, алдар гавьяаны өндөрлөгт хүрсэн хамтран зүтгэгч сайхан хүмүүсийн минь тухай материал цуглуулж, цаг зав гаргаж сэтгэл оюунаа чилээн байж эмхтгэн бичсэн, шаштир түүхийг нэгэн алтан хуудсаар зузаалсан Монголын үнэн сонины ажилтан хүндэт Н.Бөхдамбий, Ц.Түвшинбаяр, Б.Халиунаа нартаа баяр хөөрөөр дүүрэн амьдралд сайн сайхнаар амьдрахыг хүснэм.

(Зохиогч Ц.Далхаа)



Идэр залуу нас биеэ нийгэм, эх орондоо зориулсан нэрт алдарт зүтгэлтэн, доцент, гавьяат эдийн засагч, хайрт багш Ч.Түмэн, хүндэт Ардын багш профессор Ж.Нямсүрэн, гавьяат эдийн засагч, хүндэт банкир Ц.Далхаа нь хойч үедээ өөрсдийнхөө бүтээлээ “хоршин” үлдээсэн явдал нэр алдартай чухал баримт баталгаа юм.

“Түмэн шавьт” гэж алдаршсан Ч.Түмэн багшийн тухай номыг туурвин бүтээхэд Сангийн яамны ахмад ажилтан санхүүч- эдийн засагч Д.Баасанжав доктор, М.Ринчен, доктор З.Лонжид, Я.Мишиглүндэн, түүний олон шавь нар хамт ажиллаж байсан 10 гаруй хүний бичсэн дурдатгал, дурсамж, гэрэл зургууд, одоо хүртэл олны хүртээл болсоор байна.

Ч.Түмэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Хяр хармагтай гэдэг газарт Даваагийн Чимэдийн 6 дахь хүүхэд болон төржээ.

Ч.Түмэнгийн ажлын гараа нь Шүүх Яам, Сангийн яаманд бичээчээс эхэлж ахлах мэргэжилтэн, нягтлан бодохын сургууль, Санхүүгийн техникумд багш, орлогч захирал, хичээлийн эрхлэгч, Эдийн засгийн дээд сургууль, МУИС-д багшаар насан туршдаа ажилласан. Ч.Түмэн Ардын Их Хурлын депутатаар, МАХН-ын VI, VII их хуралд төлөөлөгчөөр сонгогджээ.

Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2 удаа, Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, ойн медалиудаар энгэрээ мялаажээ. Ч.Түмэн гуайг үр бүтээлт хөдөлмөр, үйл ажиллагааг төр засаг өндөр үнэлж БНМАУ-ын гавьяат багш, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, доцент, Санхүү-Банкны тэргүүний ажилтан цол тус тус хүртсэн билээ.

Ч.Түмэн 1924 оноос эхлэн нягтлан бодох, санхүү эдийн засгийн асуудлаар насаараа багшилсан манай таван үеийн багшийн нэг ХХ зууны Монголын нэрт нягтлан бодогч, санхүүч, сурган хүмүүжүүлэгч мөнөөс мөн. Ертөнцөд хүн төрдөг, хийж бүтээсэн гавьяа бүтээл нь хойч үедээ мөнхрөн дурсагдаж байдаг жамтай. Ийм ч учраас 1951 онд хувь тавилан заяа төөргөөрөө гэх үү дээ Хөвсгөл аймгаас Санхүү эдийн засгийн техникумын сургуульд Ж.Нямсүрэн, Ц.Далхаа орж, Ч.Түмэн багшаараа нягтлан бодохын хичээлийг заалган 1955 онд дүүргээд Ж.Нямсүрэн сургуульдаа багшаар, Ц.Далхаа Улсын банкинд хувиарлагдан нягтлан бодогчоор ажлынхаа гарааг эхэлж, өдгөө 60 гаран жил тасралтгүй ажиллацгааж байна. Энэ хугацаанд Ж.Нямсүрэн 10.000 гаран, Ц.Далхаа 2.000 гаран шавьтай хүмүүс юм.

- Энэ хугацаанд Ж.Нямсүрэн Аж үйлдвэрийн газрын нягтлан бодогч - эдийн засагч мэргэжилтэй болсон. МУИС, Багшийн дээд сургууль, ЗХУ-ын Москва, Ленинград, ХБНГУ-ын Берлин хотын эдийн засгийн дээд сургуулиудад мэргэжил дээшлүүлсэн. Ч.Түмэнтэй Аж үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэл, охин Н.Шинэ-Өлзийтэй “Нягтлан бодох бүртгэлийн үндэс”, “Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн товч түүх”, “Нягтлан бодох бүртгэлийн онол”-ыг Засгийн газрын тогтоол, “Яам тусгай газрын тушаал, заавар, журмын эмхтгэл” зэрэг сурах бичиг, гарын авлагыг зохион хэвлүүлсэн. Мөн “Санхүүгийн бүртгэлийн бодлого, дасгалын хураамж”, “Ахисан түвшний нягтлан бодох бүртгэл”, “Банк бус санхүүгийн байгууллагын Аудит”, “Хөвсгөл аймгийн санхүүгийн албаны түүх” зэрэг сурах бичиг, гарын авлагыг бичиж хэвлүүлсэн.
- Шүүмж, нийтлэл, дурсамж 10 гаруйг бичиж төвийн сонин сэтгүүлд нийтлүүлсэн. Хэд хэдэн удаа эрдэм

шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. Мэргэшсэн нягтлан бодогчдын үндэсний нийгэмлэгийг анх байгуулж цэгцлэн ажиллуулжээ.

- Санхүү эдийн засгийн их сургуулийн 90 жилийн ойн түүхэн номыг бичсэн.
- Ж.Нямсүрэн нь СЭЗ-ийн Техникум, коллеж, дээд сургуульдаа багш, ахлах багш, хичээлийн ба тэнхмийн эрхлэгч, орлогч захирал, захирал, зөвлөхөөр тасралтгүй ажиллаж Монгол Улсын гавьяат эдийн засагч, Ардын багшийн өндөр цолыг хүртсэн байна.
- Ардын багш Ж.Нямсүрэн нь юмыг олон талаас нь харж чаддаг хэрсүү зан, нухацтай нягт нямбай чанар, одоо байгаа туршлага, боловсрол дээрээ дөрөөлөн цааш улам бүр туршлагажиж их зүйлийг хийж чадна гэдэгт итгэлтэй хүн дээ гэж Ц.Далхаа ярив.
- Ц.Далхаа Бурханаас заяагдсан Хөвсгөл аймаг, Галт сум, Далай Ван-Чойнхор хошууны “Чингис хааны тулгын чулуу” домогт сүрлэг, Баянзүрх уулсынхаа энгэрт, эцэг Б.Цэрэндаш, эх Ш.Жавзансүрэнгийн 15 хүүхэд төрүүлэн өсгөсний 13 дахь хүү болон 1934 онд мэндэлжээ.

Ц.Далхаа сумын бага сургууль, Санхүү эдийн засгийн техникумыг 1955 онд дүүргээд, 17 настайдаа Улсын банкинд тасгийн нягтлан бодогчоор анх ажлынхаа гарааг эхлэн, улмаар дээд сургуульд орж, Бүртгэл эдийн засгийн дээд мэргэжилтэй болжээ. Банкинд өсөх наснаасаа өвөө болтлоо далласан газар ил гарч, далайсан цагт далдхан, тасралтгүй “ажиллахдаа” хийж үзээгүй албан тушаал, үе шат бүтцийн өөрчлөлт, курс сургалтанд “бүтээлцээгүй”, заавар тусгай журам тушаал тогтоолыг “үзэж хараагүй” зүйл байхгүй санж.

Хийж бүтээсэн зүйлүүд нь нүдэнд харагдаж, ул мөрөө биет эд эс нь болгоод, цаашид уламжлан хэрэглэгдэж холын хараатай, холч мэргэн ухаалаг зүйл байдагт оршино.

- Хөдөлмөрчдийн мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа заавар журмыг бүрэн боловсруулж, биечлэн нэвтрүүлсэн.
- Сурталчилгааны 200-гаад зураг плакатыг зурж, (хавчуурга хийсэн) "Сурах бичиг" номыг зохион бүтээжээ. Тухайн үеийн Хөдөлмөрчдийн гарын авлага ном болсон юм.
- Хадгалуулсан мөнгөнд олгох шагналын 2,4,6,8 хувийн хүүний таблиц, аргачлал номуудыг бүтээн гаргасан.
- Мөнгөн хадгаламжийн таних тэмдэг (**логог**) зохиожээ.
- **Монгол улсад Герман улсын "Иж бүрэн нягтлан бодох бүртгэл"-ийг нэвтрүүлжээ**

Монгол улсын яам, тусгай газруудад (1950-1960-аад онуудад) хувиа аргацаасан мемориалийн системтэй, нэгдсэн дансгүй байжээ. Төр засгаас Герман улсын нягтлан бодохын иж бүрэн системийг нэвтрүүлэх шийдэл ч гарсан байжээ. Улсын банкны бүртгэлийн хэлтсийн дарга ерөнхий нягтлан бодогч М.Тэрбиш, мөнгөн эргэлтийн мэргэжилтэн Ц.Далхааг бүртгэлийн ажлыг нэвтрүүлэхээр Герман улсад томилон явуулсан байна.

Энэ хоёр тус тусынхаа /үүрэгт/ ажлыг хариуцлагатай биелүүлжээ. Ингээд Ц.Далхаа 1964 онд Төв аймгийн банкны даргаар дэвшүүлэн томилогдон очсон. Төв аймгийн "банкны конторт" нягтлан бодох иж бүрэн /кабинет/ байгууллаа. Байгуулсан кабинетийнхаа нээлтийг аймгийнхаа нягтлан бодогчдын анхдугаар зөвлөлгөөнөөр нээж, зөвлөлгөөнд Намын Төв Хорооны нарийн бичгийн

шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. Мэргэшсэн нягтлан бодогчдын үндэсний нийгэмлэгийг анх байгуулж цэгцлэн ажиллуулжээ.

- Санхүү эдийн засгийн их сургуулийн 90 жилийн ойн түүхэн номыг бичсэн.
- Ж.Нямсүрэн нь СЭЗ-ийн Техникум, коллеж, дээд сургуульдаа багш, ахлах багш, хичээлийн ба тэнхмийн эрхлэгч, орлогч захирал, захирал, зөвлөхөөр тасралтгүй ажиллаж Монгол Улсын гавьяат эдийн засагч, Ардын багшийн өндөр цолыг хүртсэн байна.
- Ардын багш Ж.Нямсүрэн нь юмыг олон талаас нь харж чаддаг хэрсүү зан, нухацтай нягт нямбай чанар, одоо байгаа туршлага, боловсрол дээрээ дөрөөлөн цааш улам бүр туршлагажиж их зүйлийг хийж чадна гэдэгт итгэлтэй хүн дээ гэж Ц.Далхаа ярив.
- Ц.Далхаа Бурханаас заяагдсан Хөвсгөл аймаг, Галт сум, Далай Ван-Чойнхор хошууны “Чингис хааны тулгын чулуу” домогт сүрлэг, Баянзүрх уулсынхаа энгэрт, эцэг Б.Цэрэндаш, эх Ш.Жавзансүрэнгийн 15 хүүхэд төрүүлэн өсгөсний 13 дахь хүү болон 1934 онд мэндэлжээ.

Ц.Далхаа сумын бага сургууль, Санхүү эдийн засгийн техникумыг 1955 онд дүүргээд, 17 настайдаа Улсын банкинд тасгийн нягтлан бодогчоор анх ажлынхаа гарааг эхлэн, улмаар дээд сургуульд орж, Бүртгэл эдийн засгийн дээд мэргэжилтэй болжээ. Банкинд өсөх наснаасаа өвөө болтлоо далласан газар ил гарч, далайсан цагт далдхан, тасралтгүй “ажиллахдаа” хийж үзээгүй албан тушаал, үе шат бүлцийн өөрчлөлт, курс сургалтанд “бүтээлцээгүй”, заавар тусгай журам тушаал тогтоолыг “үзэж хараагүй” зүйл байхгүй санж.

Хийж бүтээсэн зүйлүүд нь нүдэнд харагдаж, ул мөрөө биет эд эс нь болгоод, цаашид уламжлан хэрэглэгдэж холын хараатай, холч мэргэн ухаалаг зүйл байдагт оршино.

- Хөдөлмөрчдийн мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа заавар журмыг бүрэн боловсруулж, биечлэн нэвтрүүлсэн.
- Сурталчилгааны 200-гаад зураг плакатыг зурж, (хавчуурга хийсэн) "Сурах бичиг" номыг зохион бүтээжээ. Тухайн үеийн Хөдөлмөрчдийн гарын авлага ном болсон юм.
- Хадгалуулсан мөнгөнд олгох шагналын 2,4,6,8 хувийн хүүний таблиц, аргачлал номуудыг бүтээн гаргасан.
- Мөнгөн хадгаламжийн таних тэмдэг (логог) зохиожээ.
- **Монгол улсад Герман улсын "Иж бүрэн нягтлан бодох бүртгэл"-ийг нэвтрүүлжээ**

Монгол улсын яам, тусгай газруудад (1950-1960-аад онуудад) хувиа аргацаасан мемориалийн системтэй, нэгдсэн дансгүй байжээ. Төр засгаас Герман улсын нягтлан бодохын иж бүрэн системийг нэвтрүүлэх шийдэл ч гарсан байжээ. Улсын банкны бүртгэлийн хэлтсийн дарга ерөнхий нягтлан бодогч М.Тэрбиш, мөнгөн эргэлтийн мэргэжилтэн Ц.Далхааг бүртгэлийн ажлыг нэвтрүүлэхээр Герман улсад томилон явуулсан байна.

Энэ хоёр тус тусынхаа /үүрэгт/ ажлыг хариуцлагатай биелүүлжээ. Ингээд Ц.Далхаа 1964 онд Төв аймгийн банкны даргаар дэвшүүлэн томилогдон очсон. Төв аймгийн "банкны конторт" нягтлан бодох иж бүрэн /кабинет/ байгууллаа. Байгуулсан кабинетийнхаа нээлтийг аймгийнхаа нягтлан бодогчдын анхдугаар зөвлөлгөөнөөр нээж, зөвлөлгөөнд Намын Төв Хорооны нарийн бичгийн

дарга Д.Моломжамц, Улсын Банкны Ерөнхий хорооны дарга П.Төмөр, Сангийн яамны орлогч сайд Б.Долгормаа, СААУГазрын бүртгэлийн хэлтсийн дарга Шарав-Аралдий нар үзэж, цаашид өргөжүүлэх талаар үүрэг даалгавар өгчээ.

Кабинетийнхаа үйл ажиллагааг өргөтгөж бүх аймаг, хотын дарга мөн санхүү, банкны дарга, нягтлан бодогч, эдийн засагчидад үзүүлэх сургууль зохион байгуулжээ. Ингээд жил хүрэхгүй хугацаанд 8 аймаг, 44 суманд кабинетийг хуулбарлан байгуулсан, Герман улсын нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн систем нэвтрэх нөхцөл бүрэлдсэн байна.

- Ц.Далхаа нягтлан бодох бүртгэлийг улсдаа нэвтрүүлэх ажлынхаа зэрэгцээгээр банкаа “Эрдэнэсийн сан”-тай болгох талаар материал цуглуулж, суурийг нь бүрэн тавьж, Монгол банк ч сантай болжээ.
- Ц.Далхаа гуай Төв аймгийн банкны даргаар удаж “Өнөр өтгөн” болсон, Төв аймагт үлдээсэн (музей) дэх нягтлан бодох бүртгэлийнхээ “кабинет”-ийг улсын хэмжээнд өргөжүүлжээ.

Мөнгө, мөнгөн гүйлгээ

Ямарч улс гүрэнд үндэсний мөнгөтэй, “Банкны ажлын 80-аад хувийг” биедээ үүрч байдаг тогтолцоотой юм. Ийм учраас мөнгөний хэрэгцээ хаана ч, хэнд ч ...онц хэрэгтэй. Мөнгөгүй ямарч албан газар ажлаа хэзээ ч явуулж чадахгүйн адил, хүнд бол үхлээс өөр замгүйг XIV далай лам байнга сургаж л байдаг шүү дээ.

Ц.Далхаа 17 настайгаасаа 83 насыг наслахдаа 60 гаран жилийг банкиндаа л өнгөрөөжээ.

Минут ч зүгээр суудаггүй хүн:

/Баримтаас дурдах минь/

- 1955 оны мөнгөн тэмдэгтийн анхны зураглал эскизийг шинэ сүлдтэйгээр анх зурж гүйлгээнд гаргажээ.
- Мөнгөн гүйлгээний холбогдолтой заавар журмууд түүгээр ч барахгүй банк, албан газруудын мөнгөн кассын дүрмийг Сангийн яамны хянан байцаах газрын дарга Б.Янжив, Монгол банкны ерөнхий нябо, нэгдүгээр орлогч Будсүрэн, гавьяат эдийн засагч Даянжамц нартай хамтран боловсруулан гаргасан хүний нэг билээ.
- Үндэснийхээ мөнгөн зоос, төгрөгийг биет байдлаар нэгтгэн цомхотгон зурж, Англи улсаар хийлгүүлэн банкнаас бэлгэнд өгөх брошуруудыг хийлгэсэн.
- Мөн мөнгөний нэгж болох хөнгөн цагаан эдлэлээр цоорхойтой бутархай мөнгийг БНХАУ-д биеэр очиж хэвлүүлжээ.
- Манай улсын үндсэн мөнгөн тэмдэгтийнхээ “Билэгдэл”-ийг өөрийн нэрийн баталгаатайгаар “Цоо шинээр” 2 янзаар гаргасан.

Мөнгөний билэгдлийг:

- Дэлхийн интернетийн “Мөнгө гэсэн хэсэгт” тавьж сурталчилсан байна. Энэ сурталчилгаа нь дэлхийн чухал үзмэр болжээ.
- Санхүү банкны “Тэргүүний ажилтан” цол тэмдгийг

зурж бүтээсэн, одоогийн байдлаар 40 гаран мянган хүнд өгөгдсөн байна.

- Өөрийн төрсөн нутаг Хөвсгөл аймгийн Галт сумын Ундрал нэгдэлд найман тракторыг өгч, өвс бэлтгэх ажлыг нэгдлээ хангаад, Говь-Алтай аймгийн хойт талын сумуудыг хангадаг байна.
- Нэгдлүүдэд УАЗ-469 машин олдохгүй байхад 10 нэгдэлд олж өгч туслан дэмжсэн хүн.
- Төв аймгийн Борнуурын САА-д гүүний, Сэргэлэн сумын Авдархангай нэгдэлд үнээний цахилгаан саалтуурыг анх буй болгуулж, сүү айргаар хөдөлмөрчдөө хангуулж байжээ.
- Төв аймгийн намын бүгд хуралд, “Банкны ажил хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт” гэсэн сэдвээр улсын хэмжээнд анх удаа илтгэл тавьж тэтгэвэр, цалинг урьдчилан олгодог, мөн банкнаас зээл олгодог журмыг тогтмолжуулах санал тавьж, улсын хэмжээнд ёсчлон мөрдүүлсэн.
- Төв аймагт ажиллаж байхдаа аймгийн төв болон Өнжүүл, сум дундын нэгдсэн эмнэлгүүдийг санаачлан шинээр бариулсан, мөн Улаанбаатарт Зүү тариурын үйлдвэрийг зээлийн хөрөнгөөр бариулснаас гадна хорт хавдрыг эмчлэхэд мөнгөн хөрөнгө одоог хүртэл өгөгдөж байна.
- Банкны системийн нэг тогтолцоог арилжааны банкны системд 1991 онд тогтооход ХААН банкыг анх гардан байгуулжээ.
- СЭЗТехникумын дэргэд банкны ажилчдын мэргэжил дээшлүүлэх, шинээр мэргэжил олгох курс 1959 онд

байгуулагдаж үүний захирлаар Ц.Далхаа хавсран ажиллаж олон шавьтай болжээ.

- Хөдөө аж ахуйн нэгдэл, САА, Тэжээлийн үйлдвэр, станцуудад 1964 оноос эхлэн ажилчин албан хаагчдын цалингийн тооцоог гэрээт цалин хөлсний системээр туршин нэвтрүүлснийг хамгийн түрүүнд Төв аймгийн Баяндэлгэр сум, Хэрлэнбаян нэгдэлд Хөдөлмөрийн баатар Намжиг дарга тууштай нэвтрүүлсэн бөгөөд энэ журмыг шинээр байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжүүдэд хэрэгжүүлсэн нь өнөөгийн нөхцөлд гол систем болсон. Үүнийг “хоршоологчид, ажилчдын” хуралд тодорхой зөвлөмж болгосон нь 610 хоршоологчид үүгээр цалин хөлсөө зохицуулж байгаа нь ажлын маш их туршлага болсон байна.
- Банкны зээл бол аж ахуй, улс гүрний хөгжилд олон талаараа хөрөнгө оруулалт болж байгаа ба зээлийг зөв зарцуулахад хамгийн анхааралтай хандаж байх талаар сонин хэвлэлд олон удаа зөвлөмж бичихийн зэрэгцээ аж ахуйн ня-бо, баланс бүхий данс бүртгэлийг ёсчлон явуулахад онцгой анхаарч явдаг хүн юм.
- Төв аймгийн банкны дарга байхдаа СААУГазартай хамтарч Жаргалант, Архустайн 1966 оны блансад иж бүрэн шинжилгээ хийж Жаргалантаас Октябрь САА-г шинээр байгуулж Архустайд байсан мярнусан хонийг Дорноговь аймгийн Сүмбэрийн САА-д шилжүүлэх ажлыг гардан хийлгэж ирсэн ажлууд нь мөнхөд дурсагдаж байна.
- Төв аймагт ажиллаж байх үедээ улсын хэмжээний овоо, сүм, хийд мөргөлийн газарт хөдөлмөрчдөөс тавьсан мөнгийг сум, улсын орлогод оруулж, мөнгийг хийж байх төмөрлөсөн авдрыг хийлгэн тавиулсан, дээрх газруудыг улсын бүртгэлд оруулж, хариуцах

газартай болгосноос гадна үүнд тавих улсын хяналттай болж, Төв аймгийн Авдрын ууланд байгаа ээж хадыг харж хамгаалах хүнийг анх удаа шийдвэрлэж өгсөн. Улсын хэмжээнд их ажил өрнүүлсэн байна. Туул голын /гэгдэж байсан / музейгээс үлэмж хэмжээний эд зүйлс дутсан юм билээ.

- Улсын төв банк Орос Монголын хувь нийлүүлсэн байх үеийн банкны архивыг эмхлэн цэгцлэлтийн ажлыг 1924 оноос шинээр хийжээ.
- Агуу их зохион бүтээгч, эрэлч, шинийг санаачлагч, сэтгэн бодогч эрдэнийн уурхай Ц.Далхаа гуай бол банкинд 17 настайгаасаа эхлэн хөдөлмөрлөөд наядавсан насыг насалж, гучин зургаан ном туурвин гаргаж, гурван зуу гаруй сурталчилгааны зураг, плакат зурж, цоо шинээр мөнгөн тэмдэгт болон бутархай мөнгө, мөнгөний билэгдэл, мөнгө хураах цүнх, лац гээд нэрлээд баршгүй зүйлүүд хийснийг банкныхан мэднэ. Түүнчлэн Орос, Хятад улсаас үл шатах авдар, сейф, шкафуудыг том жижгээр авчирч байсныг мэдэх юм даа.
- Банкны тооцооны кассуудын 80%, ХААН банкиг шинээр санаачлан байгуулсан, мөн эрдэнэсийн сангийн суурийг тавьж, цаашид хөгжих бүрэн нөхцөл хангагдсан байна.
- Далхаа гуай нь банкинд ажилласан хугацааныхаа 40%-д хяналт шалгалтын ажлыг хийж, хувь хүн, албан байгууллага банкны нэгжүүдээс бүгд наяд хүн, албан байгууллагатай холбогдсон 7 сая төгрөгийн зөрчил дутагдлыг илрүүлж, хуулийн ба албан байгууллагатай хамтарч зөрчил, хохирол төлбөрийг барагдуулж, Сангийн яамнаас улсын байцаагч гэсэн итгэмжлэл ч авч байжээ.

- Далхаа гуай хийж бүтээсэн буянт бүтээлүүд хүн бүхний нүдэнд цоо илт харагдаж, сайн бүхнийг үлгэрлэн үзүүлж, дандаа сургамж болдгоороо өвөрмөц онцлогтой, хэзээ ч гандан бууршгүй сэтгэл сайхантай, хүнд маш тусархуу, Монгол банкны итгэлт хүн дээ.
- Ц.Далхаа “Ураг төрлийн холбоо” манай улсад унтрах тал руугаа ороод байхад 2012 оноос эхлэн (уриалга гарган) сэргээсэн явдал гайхамшигтай ажил юм даа.
- Ц.Далхаа гуай нь улсдаа олон жил үр бүтээлтэй ажиллаж алдар цолоор арвинтайг дурдахад, Хүндэт банкир, жинхэнэ, академич, доктор, уламжлалт арга ухаан судлаач, гавьяат эдийн засагч, санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдэгт, улсын онцгой бүтээн байгуулагч (Алтан хүн), Одонт хүн гээд энгэр дүүрэн тэмдэгтэй.
- Ц.Далхаа гуайн эхнэр хүний эмч О.Тунгалаг нь Эрүүл мэндийн яамны Технологийн үйлдвэр судалгааны төвд ажиллаж, таван хүүхэд төрүүлж, өөрийн ухамсарт амьдралаа хүн ардынхаа эрүүл мэндэд зориулж Иммуноглобулин, Альбумин, Шиллэгэд, өвөрмөц гаам гэх мэтчилэн уурагт бэлдмэлийг санаачлан гаргаж 1991 онд Төрийн шагнал авчээ. Охин Наранцэцэг нь Улаанбаатар хот, БЗД-ийн төв эмнэлэгт эмч, Хус модны шүүсээр ханиад, бор домьг нь нунтаглан мээмний өвчинг хөхүүлэх, уулгах эмчилгээг хийдэг.
- Мөн охин Гоёцэцэг нь банкны нягтлан бодогч мэргэжилтэй, Арвайн од гоё үйлдвэрийн дарга, ард түмнийгээ бэлэн мөнгө, зээлдэн туслах сантай болох үйл ажлыг санаачлан ажилладаг юм билээ.

- Ц.Далхаа гуай 83 насыг насласан ч 2014 оноос эхлэн өөрийн хийж бүтээсэн бүтээл, бичсэн 36 ном, улс орнуудын шинэлэг туршлаган дээр тулгуурлан “Ард түмнийгээ мөнгөн хуримтлал”, “Зээлдэн туслах сан”-тай болгож, /мөнгөний гачаалалд өртөхгүй болгох томоохон зорилт тавьж ажиллаад амжилтанд хүрээд байна.
- Зах зээлийн харилцааны өнөөгийн нөхцөлд хүсэл санаачлагаараа бие биенээ дэмжин, олны хүч, буянаар мөнгөн хуримтлалтай болж бусдаас хараат бус, өр зээлгүйгээр амьдрал ахуй, бизнесээ хэвийн, эрхэлхэд туслах зорилго бүхий сан, нь иргэд хоорондын эрх зүйн харилцааг ч зохицуулахад оршино.
- Ард түмний сан нь өөрийн дүрмийн үйл ажиллагааны хүрээнд санаачлан боловсруулж гаргасан “Хамтын хуримтлал” хөтөлбөрийн зорилго, ажиллах зарчим, гэрээ, дүрэм, журам санхүүгийн хөтөлбөр схемийн бүртгэлийн мэдээлэлтэй санд (Монгол улсын иргэн бүр хамрагдаж болно).
- Гишүүнчлэгч нь сан дээр биеэр ирж сангийн бүхий л ажилтай сайтар судалж ойлгосоны үндсэн дээр сайн дураараа өөрийн хүсэл шийдвэрээ гаргаж гишүүн болох эрхтэй...
- Сангийн бүхий л үйл ажиллагаа нь зохих хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн, санд хамрагдагсдын эрх ашгийг хохироолгүй найдвартай эрсдэлгүй ажиллагааг ханган, бүх хүрээтэй холбогдсон аливаа санал хүсэлтийг шуурхай хүлээн авч шийдвэрлэж сангийн төвлөрсөн мөнгийг дүрмийнхээ хүрээнд орон байрны зардал, цалин урамшуулал, сангийн хөгжил цэцэглэлт, сургалт зэрэг шаардлагатай зүйлүүдэд захиран зарцуулах эрхтэй.

- Ц.Далхаа ард түмнээ нам төрийн бодлоготой зохицуулан мөнгөн хуримтлалын сантай, дүрэм журамтай болгож байгаа явдал юу юунаас онцлогтой ажил болж байна.

Гавьяатнуудын нөр их ажлын гол нь улсдаа иж бүрэн нягтлан бодох бүртгэлийг бүрэн нэвтрүүлж, шинэ сүлдтэй мөнгөн тэмдэгт гэх мэтчилэн олон арван шинэ шинэлэг бүтээлийг цоо шинээр хийж эх орныхоо цэцэглэлт хөгжилтийн оргил сүлд болгосон явдал юм. Нягтлан бодох бүртгэлгүйгээр ямар ч аж ахуйн нэгж, улс хөгждөггүй юм.

ТӨВ АЙМГИЙН МУЗЕЙ ДЭХ БҮРТГЭЛИЙН КАБИНЕТ



Монгол банкны хяналт шалгалтын газрын дарга агсан Д.Ганбат, Газрын ахлах ажилтан Давгадорж, Төр нийгмийн ахмад зүтгэлтэн, хүндэт банкир Ц.Далхаа, Д.Минж, Д.Дуламсүрэн, Д.Отгон нар үзээд уг музей дэх бүртгэлийн кабинет аль ч аймагт байхгүй тул цаашид өргөтгөн ажиллуулахыг анхааралдаа авсан байна.

3. Шижирбаатар

СЭТГЭЛИЙН ҮГ
Банкны лавлах багшдаа

Миний багшийг Ц.Далхаа гэдэг. Харин "Хадгаламж" Далхаа гэвэл Монгол Улсын банк, санхүүгийн нэгэн үеийнхэн сайн мэднэ. Багш минь тэртээ жилүүдэд Санхүүгийн техникум дүүргээд банкны байгууллагад ажилласан. Банкны амьд түүх төдийгүй лавлах болсон хүн. Иргэдийн хадгаламжийн талаар Монголд Далхаа багш шиг дадлага туршлагатай, мэдлэгтэй хүн байхгүй гэхэд хилсдэхгүй. Мөнгөн хадгаламжийн хүү бодох гэдэг банкныханд хүндхэн ажил. Жил бүр өчнөөн төгрөгийн зөрүү гарч хэл ам татална. Гэтэл Далхаа багш хадгаламжийн хүү боддог таблиц гаргаж банкны салбаруудад хүргэснээр дээрх дутагдал арилсан юм. Далхаа багшийн таблиц ажлын цаг хэмнэнэ, ямар ч алдаагүй зөв байдаг. Багш маань хүнлэг, нөхөрсөг. Банкны үйл ажиллагаанд гарсан дутагдал, доголдлыг үнэрч нохой мэт соргог мэдэрнэ. Түүний хараанаас гарч хяналтгүй болно гэж байхгүй.

Төв аймгийн банкны дарга байхдаа мөн л шинэ сэргэг санаа авахуулж олон банкир хүмүүжүүлсэн дээ.

Багш хэзээ ямар завандаа үүнийг хийчих вээ гэмээр хөдөлмөрч хүн.

"Айлын ном" 1, 2, 3... гэж үнэхээр айл гэрийн өдөр тутмын амьдралд хэрэг болохоор зүйл бичсэн цуврал ном гаргаж байна. Одоо 36 номтой, сонин, хэвлэлд бичсэн 200 өгүүлэлтэй банкир багшаас өөр хэн байна гэж омогшмоор байна.

Багш маань “ХААН” банкнаас тэтгэврээ тогтоолгосон. Энэ банкны галыг асаалцсан хүнд хэцүү цаг үед нь өөд татах гэж зовж л явсан хүн. Одоо “ХААН” банкиг хардаа. Монголын энэ том банк ёстой л хаан банк болсон.

Миний багш ер нь элдэвтэй хүн. Тэр зурна, бичнэ. Бас шоглоно. Багшийнхаа нэг бүтээлийг танд танилцуулья. Тэмээг бочкоор хомнож дээр нь зараа суулгажээ. Банкинд хамт ажилладаг гурван найзаа хочоор нь шоглон зурсан нь энэ. Далхаа багшийн минь ажил амьдрал өөдрөг, өнгөтэй явдаг нь хань төрийн шагналт, эмч О.Тунгалаг эгчтэй холбоотой.

Хөөрхий багш минь нэгэн насаараа банкны хөгжлийн төлөө тэмцэж явсан гэхэд умгар өрөөнд ач, зээдээ дарагдан хэвтэмгүй сайхан амьдрах хүн гэж санагдсан.

Далхаа багш шиг олон шавьтай сайн банкирт төр ч шагналаа хайрлах л ёстой санагддаг.

Гомбосүрэнгийн САРАНТУЯА



Миний бие нь Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Баянбулаг гэдэг газарт эцэг Гомбосүрэн, эх Цэрэндулам нарын ууган охин болон 1942 оны 2 сарын 15-ны өдөр мэндэлсэн билээ. 1954 онд Улаанбаатар хотын хоёрдугаар 10 жилийн 7-р ангийг төгсч, улмаар Санхүү эдийн засгийн техникумд орж, нягтлан бодогч мэргэжил эзэмшээд Төв аймгийн Их Хайрхан, Дорноговь аймгийн

Хажуу- Улааны банкны тооцооны салбарт тус тус анхдагч эрхлэгчээр нь тасралтгүйгээр 36 жил ажиллалаа. Ажиллаж байх хугацаандаа сум, аймаг, дүүргийн депутатаар 9 удаа сонгогдож, намын хороо, захиргааны гишүүний сонгуульт ажлыг тасралтгүй 21 жил хийлээ.

Хөдөлмөрийн хүндэт медаль, ойн медалиуд, Санхүү-Банкны тэргүүний ажилтан, цол тэмдэг, гавшгайч цолоор шагнагдаж, Улсын банкны хүндэт самбарт удаа дараалан тавигдаж байсан. Эхийн алдрын 1, 2-р зэргийн одонтой.

Салбарын эрхлэгчийн ажлыг хийж гүйцэтгэсэн цагаасаа эхлэн Ц.Далхаа даргынхаа бичсэн "Багшийн ном, миний ажил" номыг цаг ямагт ширээнийхээ ном болгон, зааж сургамжилсан үг бүрийг ширхэгчлэн судлан, мэдэж өөрийн гүйцэтгэх ажлыг ямар ч цаг үед сайн гүйцэтгэж байдаг учраас эрхлэн гүйцэтгэж байгаа ажил маань байнга сайнаар шалгарч, дээд газруудын шалгалт шүүлтэнд цаг ямагт онц, сайн дүн авч, шагнап урамшил үнэлэлтэндээ тэргүүлэгч нь болж байсан билээ.

Дорноговь аймагт 15 салбар тооцооны төвийн эрхлэгчийн 80-иад хувь нь Санхүү эдийн засгийн техникумын дэргэдэх Банкны ажилтан бэлтгэх, мэргэжил олгох курсийг төгссөн хүмүүс байдаг байв. Энэ курсийн захирал нь Далхаа дарга байлаа. Зааж сургамжилсан хичээл, хэлсэн ярьсан зүйлүүд нь цөм л ажил болохоор нэвтэрхий байлаа. Нэг жишээг дурьдахад мөнгөн хадгаламж эзэмшигчид олгох шагналд хүүний 6, 8 хувийн таблицийн тэр их том номыг зохион бүтээж, түүгээр нь бид хүү боддог байсны дээр багш бол олон номтой, номууд нь уншихад маш энгийн хэллэгтэй, товчхон, хамгийн ойлгомжтой байдаг нь хүний анхаарлыг татдаг.

Далхаа гуай даруу төлөв, уур уцааргүй, дандаа л инээж явдаг их л тайван дөлгөөн хүн дээ.